

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

2024.10.02

Баруун-Урт

Барилга байгууламжийн “Архитектур төлөвлөлтийн даалгавар www.urban.gov.mn системээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Тагнуул болон өвлийн хүлэмжний барилгад, хувийн хэвшлийн хөрөнгөөр Үйлчилгээний барилга-1, орон сууцны 2 барилгад даалгавар боловсруулагдсан. Орон нутгийн төсвөөр онгон сумын наадмын талбай, мал эмнэлгийн барилгуудад уламжлалтаар архитектур төлөвлөлтийн даалгаврыг боловсруулан холбогдох газруудаар баталгаажуулсан.

Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах даалгаврыг улсын төсвөөр хэрэгжих 3 төсөл (уртын голын цэцэрлэгт хүрээлэнгийн нэмэлт ажил, өвлийн хүлэмж, ганга нуурын аялал жуулчлалын цогцолбор цахилгаан хангамж) орон нутгийн төсвөөр хэрэгжих 7 төсөл буюу (наран, дарьганга, түвшинширээ баруун-урт сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, аймгийн шүүхийн тамгын газар их засвар, амгалан гэр хорооллын дэд бүтэц гэх мэт) ажлууд дээр боловсруулж холбогдох газруудаар баталгаажуулан ажиллалаа.

Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийн дагуу улсын төсвөөр сумдад хэрэгжиж байгаа-3 төсөл буюу Амбулатор барилга, 150 хүүхдийн цэцэрлэг, 320 хүүхдийн сургуулийн барилга байгууламжид, хувийн хэвшлийн хөрөнгийн 4 орон сууцны барилгад, www.urban.gov.mn системээр дамжуулан шинээр ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийг олголоо. Мөн орон нутгийн төсвөөр хэрэгжиж байгаа 15 төсөл арга хэмжээнүүдэд барилга ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийг норм дүрмийн дагуу олгосон байна.

Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах улсын комиссийн бүрэлдэхүүнийг зохион байгуулах ажлын хүрээнд улс болон хувийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 4 төсөл арга хэмжээ спорт цогцолбор, 100 хүүхдийн дотуур байр, хос өргөө болон соёмбо хотхон орон сууцуудын барилга байгууламжид тогтоол норм дүрэм журмын дагуу ашиглалтад оруулах захирамжийн дагуу ажлын хэсгийн хуралдуулан зохион байгуулж байна. Мөн орон нутгийн төсвөөр хэрэгжсэн 8 төсөл арга хэмжээнүүдэд (наадмын талбай, эрүүл мэндийн төвийн засвар, ЕБС-ийн засвар, шугам сүлжээний ажил, цахилгааны ажил гэх мэт) барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах улсын комиссийн бүрэлдэхүүнд ажиллаж байна.

Барилгын материалын, сорилт шинжилгээний лабораторит 197 дээж шинжилгээнд хамрагдсан. Үүнд лабораторит тоосго-3ш явган зам талбай-1ш Үл эвдэх-43ш бетон шоо-150ш дээжүүдэд шинжилгээ хийн үр дүнг боловсруулан цаг тухай бүрт нь хариуг олгон ажиллалаа. Барилгын материалын лабораторид ирсэн дээжээс Барилгын хөгжлийн төвийн Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид 3ширхэг (тоосго, явган зам талбайн хавтан, дайрга) дээжийг шинжилгээний хариунд гадаад хяналт хийлгээд байна.

Орон нутгийн Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагууд батлагдсан маягтын дагуу үйл ажиллагааны тайланг цахимаар www.mcis.gov.mn хаягаар 11 аж ахуй нэгж илгээсэн байна.

Сүхбаатар аймгийн ХАБЭА салбар зөвлөлийн ажлын хэсэгт ажиллаж Баруун-Урт сумын нутагт шинээр баригдаж буй 6 барилга байгууламжид барилга угсралтын ажлын талбайд ажиллаж ХАБЭА хууль, тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж ажилласан.

Барилгын материалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 4 аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцаж гарал үүсэл тодорхой барилгын материал хэрэглэх, түүхий эдийг шинжилгээнд тогтмол хамруулах хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг чанд мөрдөх, шаардлага хангахгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэхгүй чанарын стандартын шаардлага хангасан материалыг иргэдэд нийлүүлэх зэрэг мэргэжил арга зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ.

2024 онд улсын төвийн хөрөнгө оруулалтаар аймагт шинээр хэрэгжих 8 шинэ төсөл арга хэмжээ, он дамжин хэрэгжиж буй 7 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг үе шат бүрд хэрэгжүүлж гүйцэтгэл бүрийг хянаж тухайн цаг үед pimis.publicinvestment.gov.mn системээр дамжуулан баталгаажуулж ажиллаж байна.

Шинжлэх ухаан технологийн сургуулийн Барилга, архитектурын сургуулийн дэргэдэх Гиетенхикийн судалгааны хүрээлэнгийн шинжээчидтэй Сүхбаатар аймгийн сумдуудад үйл ажиллагаа зогссон барилга, мөн бүтээц, хийц эдлэлүүдэд шинжилгээ хийлгэх ажлын хэсэгт ажилласан. Үүнд

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОГССОН

- Эрдэнэцагаан сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга
- Баяндэлгэр сумын 200 хүүхдийн цэцэрлэг, 300 хүний суудалтай соёлын төв АШИГЛАЛТАД ОРСОН
- Түвшинширээ сумын хүүхдийн цэцэрлэгийн барилга ашиглалтанд орсон
- Баруун-Урт сум, Эрүүл мэндийн газрын барилга

Төлөвлөгөөт шалгалт 14 аж ахуй нэгж байгууллага, барилга угсралтын ажилд хяналт шалгалт хийхээс 7 аж ахуй нэгж байгууллагад хяналт шалгалтыг хэрэгжүүлж 6 аж ахуй нэгж байгууллагын барилга угсралтын ажил дуусаж байнгын ашиглалтанд оруудах комисс ажиллаж хүлээн авсан байна. Нэг аж ахуй нэгж буюу Эрдэнэцагаан сумын 640 хүүхдийн сургуулийн барилгын гүйцэтгэгч Дэвшил Пропортиз ХХК-д албан шаардлага хүргүүлж ажилласан.


Төлөвлөгөөт бус шалгалт: Төрийн өмчит албан байгууллага болон аж ахуй нэгж байгууллагаас ирсэн хүсэлт, гомдол мэдээлэлийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж хэрэгжүүлж, иргэний 1 гомдлын дагуу нийтийн орон сууцны барилгын зөрчилийг арилгуулсан, төрийн өмчит албан байгууллагын хүсэлтийн дагуу 5 барилга байгууламжийн төлөв байдалд дүгнэлт гаргасан.

Урдчилан сэргийлэх шалгалт: Орон нутагт хувийн болон улсын төсвөөр шинээр баригдаж байгаа барилга байгууламжид батлагдсан удирдамжийн дагуу 2 аж ахуй нэгж байгууллагын барилга угсралтын ажилд хяналт шалгалт хийж зөрчил арилгуулах албан шаарлага өгсөн.



Хот байгуулалт, Барилга орон сууцжуулалтын яамны ажлын хэсэг 9-р сарын 26-27ны өдрүүдэд Сүхбаатар аймагт ажиллаж, “Иргэдийг орон сууцжуулах” хэлэлцүүлгийг аймгийн засаг даргын тамгын газар, газрын харилцаа, барилга хот байгуулалтын газруудтай хамтран зохион байгууллаа. Хэлэлцүүлгээр эрчим хүчний хэмнэлттэй ногоон орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн орлогт нийцсэн төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, орон нутгийн ногоон хөгжлийг хурдасгах чиглэлээр иргэдийг орон сууцжуулах хэлэлцүүлэг боллоо. Хэлэлцүүлгээр Сүхбаатар аймгийн дэд бүтцийг цаашид хэрхэн тэлж, орон сууцны үнийг иргэдэд хямдаар олгох ямар боломжтойг судалж, шийдэх асуудлыг хөндөн ярилцлаа.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2023 оны Засгийн газрын чиглэлийн хүрээнд “Монгол Улсын газрын нэгдмэл сан, газар эзэмшил, ашиглалтын бүртгэл, түүний хяналтын үйл ажиллагааг шалгаж, холбогдох арга хэмжээг хуулийн хүрээнд авч хэрэгжүүлэх ажил”-ын дагуу ГЗБГЗЗЕГазрын даргын батласан удирдамжийн дагуу аймгийн 12 суманд хяналт шалгалтын бэлтгэл ажил ханган ажиллаж байна. 10 дугаар сарын 02-ны өдрөөс ГЗБГЗЗЕГазраас ирсэн шалгалтын багтай хамтран Эрдэнэцагаан сум бичигт боомод төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлаар ажиллаж байна.



Аймгийн хэмжээний 255 мониторингийн цэгт бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар судлах судалгааны ажлыг 8, 9 сард хээрийн судалгааны ажлыг хийж газрын мониторингийн системд оруулан ажиллаж нэгтгэсэн тайланг ГЗБГЗЗЕГ азарт хүргүүлэхээр байна.

Эрдэнэцагаан суманд жил бүр гэрээгээр ашиглуулдаг хадлангийн талбайг хуваарилах, гэрээ байгуулах ажлаар 125 иргэн, хуулийн этгээдтэй хадлангийн гэрээ байгуулан эргэлтийн цэгийг газарт бэхлэн хуваарилан өгч ажиллалаа.

Аймгийн 13 сумын хэмжээнд 2025 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг үүсгэн иргэд олон нийтээс санал авах, төлөвлөгөөний төслийг боловсруулах ажлыг хийн ажиллаж байна.

ГЗБГЗЗЕГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар газар эзэмшүүлэх ажил үе шаттай 13 суманд амжилттай явагдаж байна.

Төсөл сонгон шалгаруулалтаар газар эзэмшүүлэх ажил үе шаттай 13 суманд амжилттай явагдаж байна.

Халзан, Мөнххаан сумын хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлаар гүйцэтгэгч “Инженер геодези” ХХК-тай хамтран ажиллаж төлөвлөгөөний төсөлд нэмэлт санал хүргүүлэн ажиллалаа.

ЗГ-аас батлагдан ирсэн 2024 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын газрын даамлуудад чиглэл болгон төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах үүднээс эрх бүхий Засаг даргад уламжлан захирамж шийдвэр гаргуулан ажиллаж байна.

Баруун-Урт сумын газар эзэмшил, өмчлөл, ашиглалттай холбоотой иргэдээс ирүүлсэн 200 хүсэлтийг газрын кадастрын системд бүртгэн шийдвэрлэн ажилласан байна.